

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 11

Хуралдаан 2013 оны дөрөвдүгээр сарын 18-ны өдрийн 14 цаг 07 минутад эхэлж, 16 цаг 45 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 48 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Гадаад харилцааны яамны зарим газрын дарга, захирлын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none">- Дипломат ёслолын албаны дарга- Бодлого, төлөвлөлт судалгааны газрын захирал- Ази, Номхон далайн орнуудын газрын захирал- Америк, Африкийн газрын захирал- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын захирал- Гэрээ, эрх зүйн газрын захирал- Европ, Ойрх дорнодын газрын захирал- Консулын газрын захирал- Төрийн захиргааны удирдлагын газрын захирал- Хөрш орнуудын газрын захирал	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а” болон “б”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын албаны даргын албан тушаалд Раднаабазарын Алтангэрэлийг, Бодлого төлөвлөлт, судалгааны газрын захирлын албан тушаалд Цэдэндамбын Батбаярыг, Ази, Номхон далайн орнуудын газрын захирлын албан тушаалд Чулууны Баярмөнхийг, Америк, Африкийн газрын захирлын албан тушаалд Батлайн Чулуунхүүг, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын захирлын албан тушаалд Шаравын Хишигсүрэнг, Гэрээ эрх зүйн газрын захирлын албан тушаалд Бирваагийн Мандахбилэгийг, Европ, Ойрхи Дорнодын газрын захирлын албан тушаалд Нямаагийн Наранбатыг, Консулын газрын захирлын албан тушаалд Ширчингийн Сүхбаатарыг, Төрийн захиргааны удирдлагын газрын</p>

		захирлын албан тушаалд Сүхээгийн Сүхболдыг, Хөрш орнуудын газрын даргын албан тушаалд Төмөрхүлэгийн Төгсбилгүүнийг тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Цогтсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Зам тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн газрын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “б”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Ёндонгийн Манлайбаярыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батзаяад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Сангийн яамны зарим газрын даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"> - Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга - Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга - Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газрын дарга 	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а” болон “б”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p>

	<ul style="list-style-type: none"> - Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газрын дарга - Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга - Төрийн сангийн газрын дарга 	<p>Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд Жигжидийн Ганбатыг, Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын даргын албан тушаалд Тогмидын Доржхандыг, Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын даргын албан тушаалд Батсуурийн Батцэцэгийг, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын даргын албан тушаалд Хандсүрэнгийн Пүрэвсүрэнг, Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газрын даргын албан тушаалд Энхцогтын Хангайг тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн сангийн газрын даргад томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гаргуулах тухай асуудлыг Сангийн яамны саналаар хойшлуулахаар шийдвэрлэв.</p>
4	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч зарим агентлагийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p> <ul style="list-style-type: none"> - Архивын ерөнхий газар - Гаалийн ерөнхий газар - Төрийн өмчийн хороо 	<p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгийн 2013 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн ХЭГ/545 тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Архивын ерөнхий газрын дарга, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гаалийн ерөнхий газрын дарга, Засгийн газрын тохируулагч агентлаг Төрийн өмчийн хорооны даргын албан тушаалд, томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 5 дугаар сарын 21-22-ны өдөр зохион байгуулахаар тогтов.</p>

5	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд Х.Тэмүүжингийн 2013 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 4/1310 тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын албан тушаалд тус тус томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 5 дугаар сарын 21-22-ны өдөр зохион байгуулахаар тогтов.</p>
6	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Зарим аймгийн Засаг даргын албан тоот бичиг, ажлын байрны тодорхойлолтоор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 5 дугаар сарын 15-17-ны өдөр зохион байгуулахаар тогтов.</p>
7	<p>Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Зарим аймгийн ИТХ-ын даргын албан тоот бичиг, ажлын байрны тодорхойлолтоор аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 4 дүгээр сарын</p>

		18-ны өдрөөс Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 5 дугаар сарын 15-17-ны өдөр зохион байгуулахаар тогтов.
8	Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журмыг өөрчлөх тухай	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах журам-ыг нэгдүгээр, шагнуулах албан хаагчийн тодорхойлолтыг хоёрдугаар, "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгийн үнэмлэхийг гуравдугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Тогтоолыг салбар зөвлөл болон төрийн албаны бүх байгууллагуудад хүргүүлэх, хэрэгжүүлэх зохион байгуулалтын зохих арга хэмжээ авч ажиллахыг Ажлын албаны дарга /С.Цэдэндамба/-д даалгах.</p> <p>3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнах тушаалыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
9	Бусад асуудал: - Журамд өөрчлөлт оруулах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3 дахь заалтыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам-ын 7.3 дахь заалтыг дараах байдлаар өөрчлөх.</p> <p>2. "Сонгон шалгаруулалтын дүнг</p>

		<p>нийслэл болон яам, агентлагийн дэргэдэх Салбар зөвлөл ажлын 3 хоногт, орон нутаг дахь Салбар зөвлөл ажлын 7 хоногт багтаан Төрийн албаны зөвлөлд ирүүлнэ. Дүнг хуралдаанаар хэлэлцэж, тэнцсэн иргэдийг нөөцөд бүртгэсэн тухай тогтоолыг Салбар зөвлөлд хүргүүлнэ. Боловсролын газар нь сонгон шалгаруулалтын дүн, мэдээгээ харьяалах аймаг, нийслэл дэх Салбар зөвлөлд хүргүүлж, нэр дэвшүүлэх асуудлаа түүгээрээ шийдвэрлэнэ”</p> <p>3. “Заавар батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлт гаргах заавар”-ын “Долоо. Бусад асуудал. 7.1” гэсний дараах “Комисс Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн хуралдаанаар сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэхээс өмнө: 7.1.1.”, “Журам батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 60 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 2 дугаар хавсралтын “Долоо. Бусад асуудал. 7.1” гэсний дараах “Комисс Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн хуралдаанаар сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэхээс өмнө: 7.1.1.” гэсэн утга, агуулга нэгтэй хэсгийг тус тус хасах.</p> <p>4. Энэхүү өөрчлөлтийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлүүдэд хүргүүлэн холбогдох байгууллагуудад мэдээлэхийг Ажлын алба /С.Цэдэндамба/-нд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ